

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/071/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ӨГӨӨМӨР ЦЭЦЭРЛЭГИЙН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал:

Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

дддб.Од.А5 № 01/196
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ӨГӨӨМӨР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.БАТ-ӨЛЗИЙ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус цэцэрлэгийн тавилга эд хогшлын дансанд буйдан сандал 4 ширхэг, хүндэтгэлийн шкаф 1 ширхгийг 20 жилийн ойн хүрээнд эцэг эхчүүд болон ажилчдын хандиваар авсан 1,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг бүртгэн авсан байна.

Аудитын гол асуудал

Сумын ИТХ-ын 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 02 дугаар тогтоолоор 5,407.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, 5-н нэрийн 10,400.8 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна. Эрхлэгчийн тушаалаар 4,379.7 мянган төгрөгийн бусад хангамжийн материал акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 91,56 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


4126020241

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	211,033,041.04	95,345,234.87
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	165,430,727.49	51,704,463.32
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	165,430,727.49	51,704,463.32
3121	Төгрөг	165,430,727.49	51,704,463.32
31211	Төрийн сангийн харилцах	165,430,727.49	51,704,463.32
35	БАРАА МАТЕРИАЛ	45,602,313.55	43,640,771.55
354	Хангамжийн материал	45,602,313.55	43,640,771.55
35440	Түлш, шатах тослох материал	2,348,800.00	3,401,000.00
35460	Хүнсний материал	1,890,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	41,363,513.55	40,239,771.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	776,002,388.40	747,530,409.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	776,002,388.40	747,530,409.86
392	Биет хөрөнгө	771,702,388.40	743,230,409.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	803,919,150.97	803,919,150.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(72,476,549.76)	(86,403,166.44)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,533,968.00	40,580,168.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,213,061.75)	(29,106,914.99)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,973,282.72	32,219,002.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,637,600.96)	(19,613,216.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	11,972,527.00	8,672,527.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,960,713.82)	(8,672,527.00)
39217	Ном	1,591,386.00	1,635,386.00
393	Биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	4,300,000.00	4,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	987,035,429.44	842,875,644.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	987,035,429.44	842,875,644.73
51	Засгийн газрын хувь оролцоо	987,035,429.44	842,875,644.73
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	226,954,332.77	226,954,332.77
51101	Өмч: - төрийн	226,954,332.77	226,954,332.77
512	Хуримтлагдсан үр дүн	750,684,455.57	606,524,670.86
51210	Өмнөх үеийн үр дүн	750,684,455.57	750,684,455.57
51220	Тайлант үеийн үр дүн	-	(144,159,784.71)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,396,641.10	9,396,641.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	987,035,429.44	842,875,644.73

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	657,403,934.00	486,926,051.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	607,539,234.00	3,020,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	12,258,434.00	3,020,000.00
122	Тусламжийн орлого	595,280,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,864,700.00	483,906,051.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	442,212,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	442,212,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,864,700.00	41,693,151.74
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,864,700.00	41,693,151.74
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	545,090,180.71	629,469,481.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	545,090,180.71	629,469,481.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	530,721,653.83	624,222,633.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,722,758.69	437,983,009.17
210101	Үндсэн цалин	244,728,005.04	275,451,171.49
210102	Нэмэгдэл	117,333,703.65	155,770,837.68
210104	Урамшуулал	2,661,050.00	6,761,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,569,749.40	50,248,775.00
210201	Тэтгэврийн даатгал	31,576,987.32	33,972,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,569,829.94	4,101,476.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,244,494.38	2,387,593.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,937,489.80	1,950,850.76
210205	Эрүүл мэндийн даатгал	7,240,947.96	7,836,553.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,902,573.12	37,640,951.74
210301	Гэрэл, цахилгаан	7,112,173.12	10,687,151.74
210302	Түлш, халаалт	24,118,400.00	23,609,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,672,000.00	3,344,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,354,550.00	14,005,992.00
210401	Бичиг хэрэг	1,039,700.00	2,790,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,785,350.00	5,382,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,529,500.00	1,453,500.00
210408	Бараа материал акталсны зардал	-	4,379,742.00
2105	Норматив зардал	45,899,410.00	50,112,930.00
210502	Хоол, хүнс	45,899,410.00	50,112,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	4,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	270,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	4,530,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,818,000.00	1,360,000.00
210702	Дотоод албан томилолт	1,818,000.00	1,360,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,211,750.00	3,903,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,455,750.00	1,885,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	756,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	1,262,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,242,862.62	24,167,225.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,210,210.00	714,450.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	24,032,652.62	23,452,775.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,368,526.88	5,246,848.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,368,526.88	5,246,848.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,368,526.88	5,246,848.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	112,313,753.29	(137,296,581.71)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	6,863,203.00

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	102,683.28
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	6,760,519.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(6,863,203.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	112,313,753.29	(144,159,784.71)

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	645,145,500.00	483,906,051.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	595,280,800.00	-
122	Тусламжийн орлого	595,280,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	49,864,700.00	483,906,051.74
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	442,212,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	442,212,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,864,700.00	41,693,151.74
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,864,700.00	41,693,151.74
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	527,500,888.09	602,835,164.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	527,500,888.09	602,835,164.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	513,132,361.21	597,588,315.91
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,722,758.69	437,983,009.17
210101	Үндсэн цалин	244,728,005.04	275,451,171.49
210102	Нэмэгдэл	117,333,703.65	155,770,837.68
210104	Урамшуулал	2,661,050.00	6,761,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,569,749.40	50,248,775.00
210201	Тэтгэврийн даатгал	31,576,987.32	33,972,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,569,829.94	4,101,476.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,244,494.38	2,387,593.82
210204	Ажилгүйдлийн даатгал	1,937,489.80	1,950,850.76
210205	Эрүүл мэндийн даатгал	7,240,947.96	7,836,553.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,496,173.12	38,693,151.74
210301	Гэрэл, цахилгаан	7,112,173.12	10,687,151.74
210302	Түлш, халаалт	24,712,000.00	24,662,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,672,000.00	3,344,000.00
2105	Нормативт зардал	46,469,110.00	48,222,930.00
210502	Хоол, хүнс	46,469,110.00	48,222,930.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	150,000.00	1,262,750.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	150,000.00	1,262,750.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,724,570.00	18,177,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,538,660.00	13,986,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,185,910.00	4,190,950.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,368,526.88	5,246,848.26
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	14,368,526.88	5,246,848.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,368,526.88	5,246,848.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	117,644,611.91	(113,682,264.17)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	44,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	44,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	44,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(44,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	117,644,611.91	(113,726,264.17)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	47,786,115.58	165,430,727.49
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,430,727.49	51,704,463.32

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	638,370,702.28	874,721,676.15
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	638,370,702.28	874,721,676.15
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	112,313,753.29	112,313,753.29
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	750,684,455.57	987,035,429.44
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	750,684,455.57	987,035,429.44
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	750,684,455.57	987,035,429.44
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(144,159,784.71)	(144,159,784.71)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	226,954,332.77	9,396,641.10	606,524,670.86	842,875,644.73

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	628,879,300.00	483,906,051.74	144,973,248.26	76.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	46,940,000.00	41,693,151.74	5,246,848.26	88.8
132001	Орон нутгийн төсвөөс	46,940,000.00	41,693,151.74	5,246,848.26	88.8
1310	УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ	449,397,500.00	442,212,900.00	7,184,600.00	98.4
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	449,397,500.00	442,212,900.00	7,184,600.00	98.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	132,541,800.00	-	132,541,800.00	0.0
1200042	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	132,541,800.00		132,541,800.00	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	629,088,300.00	597,632,315.91	31,455,984.09	95.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	629,088,300.00	597,632,315.91	31,455,984.09	95.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	629,088,300.00	597,632,315.91	31,455,984.09	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	449,798,500.00	437,983,009.17	11,815,490.83	97.4
210101	Үндсэн цалин	301,582,400.00	275,451,171.49	26,131,228.51	91.3
210102	Нэмэгдэл	141,413,400.00	155,770,837.68	(14,357,437.68)	110.2
210104	Урамшуулал	6,802,700.00	6,761,000.00	41,700.00	99.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,954,500.00	50,248,775.00	5,705,725.00	89.8
210201	Тэтгэврийн даатгал	37,962,500.00	33,972,300.00	3,990,200.00	89.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,498,000.00	4,101,476.44	396,523.56	91.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,249,000.00	2,387,593.82	(138,593.82)	106.2
210204	Ажилгүйдлийн даатгал	2,249,000.00	1,950,850.76	298,149.24	86.7
210205	Эрүүл мэндийн даатгал	8,996,000.00	7,836,553.98	1,159,446.02	87.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	43,940,000.00	38,693,151.74	5,246,848.26	88.1
210301	Гэрэл, цахилгаан	10,140,000.00	10,687,151.74	(547,151.74)	105.4
210302	Түлш, халаалт	31,500,000.00	24,662,000.00	6,838,000.00	78.3
210303	Цэвэр, бохир ус	2,300,000.00	3,344,000.00	(1,044,000.00)	145.4
2105	Нормативт зардал	52,039,000.00	48,222,930.00	3,816,070.00	92.7
210502	Хоол, хүнс	52,039,000.00	48,222,930.00	3,816,070.00	92.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,953,000.00	1,262,750.00	1,690,250.00	42.8
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,953,000.00	1,262,750.00	1,690,250.00	42.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,403,300.00	18,221,700.00	3,181,600.00	85.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,350,500.00	13,986,750.00	2,363,750.00	85.5
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	5,052,800.00	4,234,950.00	817,850.00	83.8
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		165,430,727.49		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		51,704,463.32		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 1,427,137.3 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 5 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.
- Хандиваар авсан 1,800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө дансанд буруу бүртгэсэн байна.
- Хандиваар авсан 1,220.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материалын дансанд буруу бүртгэсэн байна.
- Урсгал үйл ажиллагааны 437,037.9 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн.
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үлдэгдлийн 987,035.4 мянган төгрөгийг тайлагнаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2-т “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар илэрсэн 4,668.6 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 5,703.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 Залруулаагүй зөрчил

Аудитаар нийт 4,668.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч 2 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлээ.

5.2.1 Албан шаардлага

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 4,668.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь МУЗГ-ын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 237 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" журмыг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасантай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон журмыг дагуу өгөөгүй зөрчлийг давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5-д "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3-д "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, "иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

2.Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 147 ширхэг 33,761.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" тухай 271 дүгээр тогтоолын 7.1-д "төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ", Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийг чанар байдлыг үнэлэн, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, Төв аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж шийдвэрлүүлэн, бүртгэх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд төсвийн хөрөнгөөр авсан 44.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байна.	1	44.0			1	44.0	1	44.0		
2	Хандиваар авсан 1,800.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан-үндсэн хөрөнгө дансанд буруу бүртгэсэн байна.	1	1,800.0			1	1,800.0	1	1,800.0		
3	Хандиваар авсан 1,220.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан-бараа материалын дансанд буруу бүртгэсэн байна.	1	1,220.0			1	1,220.0	1	1,220.0		
4	Урсгал үйл ажиллагааны 437,037.9 мянган төгрөгийн санхүүжилтийг хандив тусламж дансанд буруу бүртгэсэн.	1	437,037.9			1	437,037.9	1	437,037.9		
5	Өмчийн өөрчлөлтийн тайлангийн өмнөх оны үлдэгдлийн мянган төгрөгийг тайлагнаагүй.	1	987,035.4			1	987,035.4	1	987,035.4		
	Дүн	5	1,427,137.3			5	1,427,137.3	5	1,427,137.3		

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 4,668.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	4,668.6			1	4,668.6	-	-				
2	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-			-	-	1	-				
3	Байгууллагын үндсэн үйл ажиллагаанд ашиглагдаж буй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 147 ширхэг 33,761.3 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1	-			-	-	1	-				
	Дүн	3	4,668.6			1	4,668.6	2	-				



ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 50-20810579-ТӨА-2026/071/НА-СТА-ТШЗ Зуунмод сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэг нь тайлант онд Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 4,668,600 (Дөрвөн сая зургаан зуун жаран найман мянга зургаан зуун) төгрөгөөр дутуу зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.4-т "Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцоох аргачлал, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх үйлчилгээний стандарт, тэдгээрийн орцын болон төсвийн нормативыг Засгийн газар тогтооно", Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 237 дугаар тогтоолын 1-т Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 3000 (гурван мянга) төгрөгөөр, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг болон уртасгасан цагаар ажиллах бүлэгт хамрагдаж байгаа хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 4100 (дөрвөн мянга нэг зуун) төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоосугай" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан нормативын дагуу цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг тооцож олгох, зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төв аймгийн Жаргалант сумын Өгөөмөр цэцэрлэгийн Эрхлэгчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Бат-Өлзий, нягтлан бодогч Д.Эрдэнэбат нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ч.МӨНХТУЯА

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn